



## ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

### ДУНДГОВЬ АЙМАГТ ХИЙСЭН АЖИГЛАЛТЫН ДҮН

#### МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форум нь Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөний Дундговь аймаг дахь салбар зөвлөлд “Цагдаагийн газрын мэдээллийн ил тод байдал” сэдвийн хүрээнд мониторинг хийх тэтгэлэг олгосон билээ. Тус мониторингийн хүрээнд цагдаагийн байгууллагаас иргэдэд өгч буй мэдээллийн төрөл, чанар, хүртээмж, ил тод, нээлттэй байдал, өнөөгийн төлөв, мэдээлэл авах явцад иргэдийн эрх зөрчигдөж буй эсэх талаар мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх, цаашид анхаарах асуудлыг тодруулахыг зорьсон.

НДЭХ-ий салбар зөвлөл мониторингийн хугацаанд аймгийн Цагдаагийн газартай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж ажиллав. Мониторингийн гол үр дүн, зөвлөмжийг энэхүү цувралаар хүргэж байгаа ба дэлгэрэнгүй тайланг бүрэн эхээр нь [www.forum.mn](http://www.forum.mn) цахим хуудаснаас үзнэ үү.


#### МОНИТОРИНГИЙН ДҮН

- Цагдаагийн байгууллагын хаалганы хоёр талд мэдээллийн самбар байрлуулсан нь иргэд мэдээлэлтэй танилцах боломжийг бүрдүүлсэн хэдий ч тавигдсан мэдээлэлд тохирох агуулга тусгагдаагүй байна. Тухайлбал, “Хууль” хэсэгт байгууллагын даргын мэндчилгээ, “Үйл ажиллагааны мэдээлэл” хэсэгт 4 сар гаруйн өмнө болсон үйл явдлын мэдээ, “Дүрэм” хэсэгт Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэл өгөх утасны дугаар, “Худалдан авах ажиллагааны ил тод байдал” хэсэгт лизингийн утас, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга зэрэг мэдээлэл тавигджээ. Мониторингийн явцад нийт 5 удаа ажиглалт хийсэн боловч дээрх мэдээлэл солигдоогүй бөгөөд сүүлийн удаа үзэхэд дотоод хэрэгцээндээ ашигладаг мэдээллийн самбараар сольсон ч иргэдэд түгээх мэдээлэл тавигдсангүй.
- Аймгийн цагдаагийн газрын цахим хуудсыг шинжилбэл мэдээллээ цаг тухайд нь шинэчилж байсан.
- Цагдаагийн газрын фэйсбүүк хуудас 2017 оны 8-р сарын 29-ний байдлаар 3428 хандалттай, 3418 дагагчтай байсан ба мэдээллийг тухай бүрд шинэчилж байв. Тэдгээрээс байгууллагын алба хаагчийг шагнаж урамшуулсан, цол нэмсэн тухай мэдээлэл илүү хандалттай байв. Харин малын хулгай, эрүүгийн хууль, зөрчлийн тухай хуулийн холбоотой мэдээлэлд хандалт бага байлаа.
- Байгууллагынхаа мэдээллийн талаар цагдаагийн алба хаагчид дүгнэхдээ хэт албаны хэллэгтэй, дотоод үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл давамгай байгаа нь иргэдийн хэрэгцээг төдийлөн хангахгүй байна гэв. Мөн мэдээллийн ил тод байдлыг хангахад шаардлагатай төсөв, тоног төхөөрөмж, боловсон хүчин дутмаг, хэвлэл мэдээллийн байгууллагатай

хамтын ажиллагаа бага байгаа нь иргэд ам дамжсан ташаа мэдээлэл авах үндэс болж байна хэмээв. Мэдээллээ түргэн шуурхай түгээх, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, мэдээллийг иргэдийн хэрэгцээнд тулгуурлан бэлтгэх шаардлагатай байгааг мөн онцолсон.

- Цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, гэр бүл, хүүхэд, залуучуудын болон боловсролын зэрэг газрууд дүгнэхдээ цагдаагийн байгууллага мэдээллээ бүрэн дүүрэн өгч чадахгүй байна гэж дүгнэж байв. Хэрэв мэдээллээ цаг алдахгүй өгвөл гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ахиц гарна, тиймээс иргэдэд ойлгомжтой мэдээлэл түгээх чадавхтай боловсон хүчин бэлтгэх, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахыг зөвлөж байв.
- Цагдаагийн байгууллага фэйсбүүк, телевизээр голдуу мэдээлэл өгдөг, нээлттэй хаалганы өдөр, сургалт хийлээ гэдэг ч хамрагддаг хүний тоо цөөн. Голдуу танил талдаа үйлчилдэг, ялгавартай ханддаг, харилцааны соёлгүй хэмээн иргэд шүүмжилсэн.

### Ямар эх сурвалжаас иргэд цагдаагийн байгууллагын мэдээлэл авдаг вэ?



- Мэдээлэл авдаг гол эх сурвалжийг хүн ихтэй зах, худалдааны төвөөр үйлчлүүлж байгаа 93 иргэнээс санал асуулгаар тодруулахад голдуу фэйсбүүкээр мэдээлэл авдаг гэсэн ба орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс гэсэн нэг ч хариулт байсангүй. Эндээс харахад иргэд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авах нь ховор аж. Асуулгад оролцсон иргэдийн 26 хувь цагдаагийн байгууллагын мэдээлэл хэрэгцээтэй, 73 хувь нь зарим мэдээлэл хэрэгцээтэй байдаг гэж үзсэн бөгөөд шинэ хууль тогтоомж болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл,

сэрэмжлүүлэг, гэмт хэргийн гаралт, илрүүлэлт, цахимаар дамжуулан авах боломжтой мэдээлэл, өргөдөл, гомдлын мөрөөр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээлэл авахыг илүүтэй хүссэн байна.

- Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлж байсан, хариуцлагатай алба хашдаг, үйлчилгээ авч байгаагүй зэрэг нийт 50 иргэнтэй ярилцлага хийхэд тэдний 86 хувь (43 иргэн) нь тус байгууллагын мэдээллийг хаанаас авахаа сайн мэдэхгүй гэсэн ч шаардлагатай үед үйлчилгээ авсан гэж 94 хувь нь хариулсан. Харин малчид Багийн ИНХ-ын үеэрээ цагдаагийн хэсгийн байцаагчаас мэдээлэл авдаг ажээ.

### ЗӨВЛӨМЖ

- Шинэ хууль тогтоомж, дүрэм журмыг мэдээлэхдээ иргэдийн анхаарал татахуйц шинэлэг арга барил ашиглах;
- Мэдээлэл түгээх уламжлалт арга болох мэдээллийн самбар ашиглахдаа мэдээллийг тогтмол шинэчилж байх;
- Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;
- Зорилтот бүлэгт тохируулж мэдээллийн агуулгыг боловсруулах.



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ  
Жамьян гүний гудамж -5/1,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240,  
Утас: (976-11) 313207  
Факс: (976-11) 324857

Энэ дугаарт НДЭХ-ий Дундговь аймаг дахь салбараас Цагдаагийн газрын үйл ажиллагааны ил тод байдалд хийсэн мониторингийн үр дүнг хэвлэн нийтлэв. Энэхүү мониторинг нь НДЭХ-ий Дундговь аймаг дахь салбараас ирүүлсэн сэдвийн хүрээнд ННФ-ын санхүүжилт болон арга зүйн дэмжлэгтэйгээр хийгдсэн болно.